

1

ШИНЭ, ХУУЧИН ЭДИЙН ЗАСАГ: “ШИНЖЭЭЧДИЙН ШИНЭ ҮЕ”

П.Лувсандорж

Монгол оронд үндэсний эдийн засагчдын судалгааны ажил зогсонги байдалд ороод 20-иод жил боллоо. Энэ нь эдийн засгийн шилжилттэй холбоотой. Судлах зүйлс нь өөрчлөгдөж, судлаачид өөрсөдөд нь суралцах хэрэгцээ гарсан хэрэг. Сургалтын ажлыг өрнүүлэхээс судалгааны ажил хамааралтай болж, одооноос шинжээчдийн шинэ үе бойжих шатандаа хүрч ирээд байна. Энэ бүхэн хуучин, шинэ эдийн засгийн зааг дээр болж байна. Төвлөрсөн төлөвлөгөөтэй байсан хуучин эдийн засагт: төр гэсэн нэгэн өмчийн эзэн орц, гарц, орлого, зарлага гээд бүхий л үйл ажиллагааг нэгэн дор төвлөрүүлж нэгдсэн төлөвлөгөөгөөр удирдана. Зах зээлийн гэх шинэ эдийн засагт бол өрхийн аж ахуй, пүүс, компани, Засгийн газар гэсэн олон өмчийн эзэн орц, гарц, орлого, зарлага гээд бүхий л үйл ажиллагааг тус тусдаа бие дааж явуулах бөгөөд энэ бүхнийг зах зээл гэх “үл үзэгдэх” гар зохицуулна. Эдгээр зарчмын ялгаанаас үүдэлтэй эрс тэс ялгаа олон гарна.

Манай орны тухайд, эдийн засгийн шинжлэх ухааны хүрээнд гэхэд судлах зүйлс шинэ болсон, тухайлбал, төрийн өмчийг хувьчлах, хувийн секторыг дэмжих, үнийг чөлөөлөх, орлогыг дахин хуваарилах, хэрэглээг зохисжуулах, пүүс, компаниудыг шинээр бий болгох, хөдөлмөрийн, бүтээгдэхүүний, мөнгөний болон санхүүгийн зах зээлүүдийг төлөвшүүлэх, гадаад худалдааг либералчлах, нийт эдийн засгийг нээлттэй болгох гээд эдийн засгийн эрх чөлөөтэй холбоотой зах зээлийн эдийн засгийн олон асуудлыг судлах хэрэгцээ гарсан. Энэ бүгд хуучин судлах зүйлсийг үгүйсгэж буй, судлаж байгаагүй шинэ сэдвүүд. Шилжилтийн энэ үед олон улсын судлаачид онцгой үүрэг гүйцэтгэв. “Муужруулах эмчилгээ”, тогтворжуулах бодлого, цаг үеийн олон тооны

хөтөлбөр, төслийг тэд боловсруулсан. Үндэсний судлаачдын хүрээнд хийгдсэн цөөн тооны ажилд Үндэсний хөгжлийн үзэл баримтлал, цогц бодлого, цаг үеийн хөтөлбөр, төслүүд багтана.

Зах зээлийн эдийн засагт судалгааны арга өөр болохоор, шинэ арга зүйг эзэмших хэрэгтэй болж байгаа юм. Орчин үеийн эдийн засгийн шинжлэх ухаан өөрийн гэсэн зарчим, онол, загвар, бодлоготой. Тэр бүхнийг “шинжлэх ухааны лаборатори” гэвэл “монгол асуудлыг” түүнд оруулж судлана гэсэн үг. Хуучин нөхцөлд судлаачийн хувийн дүгнэлт, санал судалгааны гол үр дүн болдог байсан бол шинэ арга хэрэглэсэн нөхцөлд шинжлэх ухааны шууд хариу гардаг гэж болно. Жишээлбэл: төрөөс янз бүрийн хөтөлбөр, төсөл хэрэгжүүлээд байхад ажилгүйдэл, ядуурал яагаад буурахгүй байна гэсэн “монгол асуудалд” хөдөлмөрийн зах зээлийн хөгжил сул дорой, тэнд мэрэгшлийн болон цалингийн өрсөлдөөн үгүйлэгдэж байна гэсэн “шинжлэх ухааны хариу” гарна. Шинжлэх ухааны гэдэг нь энд: онолын сэтгэлгээний сургуулиудыг үндэслэгчид, Кейнсийн сургаал, Фридманы онол, шинэ сонгодог сургууль, шинэ кейнсчүүд, орчин үеийн эдийн засгийн шинжлэх ухааны шинэ чиглэл, шинэ хандлагуудын бүтээлийг шинжилгээний багаж хэрэгсэл болгож хэрэглэнэ гэсэн хэрэг. Тухайлбал: эдийн засгийн өсөлтийг Солоугийн загварт оруулж үйлдвэрлэлийн функцээр, хөдөлмөрийн зах зээл, ажилгүйдэл, инфляцийг Окунийн хууль, Филлипсийн муруйгаар; макро эдийн засгийн тэнцвэр болон бүтээгдэхүүн, мөнгө, санхүүгийн зах зээлүүдийн судалгааг IS; LM загваруудаар нөлөөлөх хүчин зүйлсээр тус тус судлах болно.

Шинэ нөхцөл, байдал, шинэ цаг үед хуучин байгууллагыг өөрчилж хуучин шинжээчийг давтан сургахаас илүүтэй шинжилгээний шинэ байгууллага, шинжээчдийн шинэ үеийг эхнээс нь шинээр бий болгох нь шинэ бөгөөд сонгодог арга. Энэ утгаар, манай орны нөхцөлд, эдийн засгийн шинжлэх ухааны хүрээнд сургалт нь судалгааны угтвар болж, их сургуулиудын шинжлэх ухаан нь академийн, пүүс, компаны шинжлэх ухаануудаас урьдаж бий болох шинэ хандлага тодроод байна. Өөрөөр, эдийн засгийн шинжлэх ухааны тухайд: Монгол Улсын шинжээчдийн шинэ үе их, дээд сургуулиуд дээр бэлтгэгдэж байна. Энэ бол цаг үедээ зөв хийгдсэн сургалтын шинэчлэлийн бодит үр дүн. Судлаачдын энэхүү нөөц хүчинд түшиглэсэн академийн болон үйлдвэрлэлийн хүрээний судлаачид, судалгааны байгууллагууд аажмаар бий болох хандлага ажиглагдаж байна.

МУИС-ийн багш-судлаач нарын Монголын эдийн засгийн өсөлтийн болон бүтцийн прогноз, монгол хүний хөгжил, хөдөлмөр, бүтээгдэхүүн, санхүүгийн зах зээлүүдийн тогтолцоо; бусад их, дээд сургуулиудын багш-судлаачдын Монгол орны хүн амын амьдралын чанар, хөдөө аж ахуйн газрын эдийн засгийн үнэлгээ зэрэг судалгааны ажлууд шинэ цаг үеийн шаардлагын түвшинд хийгдсэн бүтээлүүд болжээ гэж талархаж байна. Ер нь манай багш-судлаачид

өөрийн орны эдийн засгийн амьдралын ямарч асуудлыг аль ч түвшинд; онолтой нь, загвартай нь, бодлоготой нь, зөвлөмжтэй нь, дүгнэлтэй нь, саналтай нь судлаж чадах шинэ түвшинд хүрээд иржээ гэсэн итгэл төрүүлж байна.

МУИС-ийн эдийн засагч багш нар Монголдоо анхны сурах бичгийг орчуулж, дараа нь бичиж эрдэм түгээх ажлыг хошуучилж ирсэн нь гавъяатай хэрэг. Улмаар, тэд хэдхэн жилийн дараа макро, микро эдийн засгийн үндэсний сурах бичиг бэлтгэх хүнд боловч гавъяатай үйлс бүтээж байгаад талархаж байна. Үндэсний сурах бичиг нь Монголдоо анхлаж байгаа төдийгүй, үндэсний эдийн засгийн судалгаанд тулгуурлан бичигдэх ёстой.

Шинжээчдийн залуу үеийг шинэ цаг үед боловсрол олж авсан 25-35 насны залуус, шинэ сэтгэлгээ бүхий бусад насны хүмүүс бүрдүүлж байна. Ихэнхдээ багш нар байх юм. Шинэ үеийн хүний энэ нөөцийг өсгөж бойжуулах, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч түвшинд дэвшүүлж ажиллуулах, улмаар богино хугацаанд зонхилох байртай болгох хүний нөөцийн шинэ бодлогыг тууштай хэрэгжүүлэх нь чухал.

Шинжээчдийн шинэ үеийн нэг хэсэг нь гадаадад ажиллаж, суралцаж байгаа. Энэ бол бага гэхгүй их хүч.. Боловсролыг сурах чадвар болгон идэвхжүүлэгч онлайн сургалтыг Монголд байгуулахад, АНУ-ын Миззурийн их сургуулийн судлаач доктор Я.Борчулууны, Мэдээллийн технологийн монгол бүтээгдэхүүн төрүүлэх, мэдлэгт тулгуурласан монгол нийгэм байгуулах судалгааны ажилд Майкрософт компанид ажиллаж байгаа Л.Бат-Өлзийн туслалцаа хэрэг болно. Гадаадад ажиллаж, сурч байгаа монгол иргэдийн оюуны чадавхийг хөгжилд хэрэглэх монгол тогтолцоо хэрэгтэй. БСШУЯ, Сангийн яам санаачлахад л болно. Манай иргэдэд судалгааны ажлынхаа хүрээг гадаадын шилдэг судлаачдаар өргөтгөх боломж бас байгаа.

Шинэ үеийн шинжээчдийг дэмжигчид, ивээн тэтгэгчид нь тэдний бүтээлийн захиалагчид болох Засгийн газар, яамад, агентлаг, пүүс компаниуд билээ. Тэдний үйл ажиллагаа нь шинжлэх ухааны үндэстэй байх ёстой. Бодлого, хөтөлбөр, стратегийн болон мастер төлөвлөгөөнүүд, төрөлжсөн төслүүд хэрэгжүүлдэг байх ёстой. Байгууллагаа, албадаа шинэ мэдлэгтэй хүний нөөцтөй болгож чадвал үйл ажиллагаандаа амжилт олж зах зээлийн, магадгүй улс төрийн өрсөлдөөнд ялах шинэ хүч чадалтай болж байгаа нь тэр. Танил тал болон чадалтай гэгдэх 1-2 хүний хүчинд найдаж ажилладаг хуучин цаг өнгөрөв бололтой.

Судлаачдын шинэ халааг зарцааж болохгүй, эхнээс нь халуун дэмжлэг үзүүлэх нь зөв. Магистр, докторын сургалтанд гадаадад явуулж байгаа сайн ажлыг өргөтгөж үргэлжлүүлэх хэрэгтэй. Бас гадаадын зээл, тусламжаас нэгэн хэсгийг нь судалгаанд зориулж өндөр мэрэгшлийн судлаачдыг гадаадаас урих, тэднийг

дагуулж үндэсний шинжээчдийг сургах шинэ ажил өрнүүлэх хэрэгтэй. Энэ бол үйлдвэр, барилгаас дутуугүй хүмүүн капиталд зориулж байгаа үнэтэй хөрөнгө оруулалт билээ.

Эдийн засгийн хөгжил дорой бол шинжлэх ухааныг шингээн авч бүрэн чадахгүйн адил шинжлэх ухааны шинэ мэдлэггүйгээр эдийн засаг бас олигтойхон хөгжиж чадахгүй. Шинжлэх ухаан, хөгжил хоёр харилцан хамааралтай гэсэн үг.

Монгол Улсын үндэсний эдийн засаг шилжиж буй, хөгжиж буй шинж төлөвтэй. Шилжилтийн асуудал шийдвэрлэгдэж дуусаагүй байхад хөгжлийн асуудлаа шийдвэрлэх хэрэгтэй болж шилжилт, хөгжил хоёр нэгэн үе шатанд нийлэн нэгдэж байна. Энэ бол хөгжиж буй эдийн засгийн хөгжлийн нэгэн зүй тогтол бололтой. Монголын эдийн засгийн салбар хоорондын интеграц сул, өрөөсгөл бүтэцтэй. Саяхан болтол мал аж ахуй голлож байсан бол одооноос уул уурхай зонхилох байр суурьтай болж байна. Боловсруулах үйлдвэр хөгжүүлэх шаардлагатай. Хувийн секторын пүүс, компанийн эдийн засгийн хүч чадал дорой, төрийн дэмжлэг хэрэгтэй. Энэ бол хөгжиж буй эдийн засгийн хөгжлийн бас нэгэн зүй тогтол байж таарна. Эдгээр болон бусад олон асуудлыг шийдвэрлэхэд эдийн засгийн судалгаа чухал үүрэг гүйцэтгэнэ. Шинжилгээ, судалгааны үр дүнг шингээж чадаж байвал үндэсний эдийн засаг түргэн, тогтвортой хөгжих болно.